



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/34

Бат-Өлзий сум

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ойн нөөцийг хамгаалах байгаль хамгаалагч нарыг унаажуулах авто мотоцикл худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)

Гишүүд: Г.Болормаа (Эрүүл мэндийн төвийн Нягтлан бодогч)

Н.Нямхүү (Иргэний төлөөлөл)

Б.Болормаа (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: Э.Дашдулам (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Н.Орхонтуул)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Э.Дашдулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН